



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 8/25

Номгон

Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай

Зөвшөөрлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, 19.20 дахь заалт, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Өөрийн хүсэлтээр үйл ажиллагаагаа зогсоож буй “Үүрд буян оргил” ХХК-ийн (РД:3142272) эзэмшиж буй Хүний эм, эмнэлгийн хэрэгслийг жижиглэнгийн үнээр хангах (Хоёрдугаар зэрэглэл) ЭСХ-23/03/002 дугаар бүхий тусгай зөвшөөрлийг 2026 оны 04 дүгээр сарын 24-ны өдрөөс хүчингүй болсонд тооцсугай.

2.Хүчингүй болсон тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хураан авч, мэдээллийн санд зохих өөрчлөлтийг оруулахыг Комиссын ажлын алба, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн хэлтсийн мэргэжилтэн (О.Найгалмаа)-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Г.ЛХАГВА-ОЧИР



642001073